



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин Сайдын яамны албан ажлын хэрэгцээнд зориулан хавсралтад заасан техникийн үзүүлэлт бүхий суудлын автомашин худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Даваасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 03 дугаар сарын 06 -ны өдрийн
...50...дугаар тогтоолын хавсралт



**Монгол Улсаас ОХУ-д суугаа элчин Сайдын яаманд худалдан авах
автомашины техникийн үзүүлэлт**

| Д/д | Автомашины техникийн үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|-----|--|-------------|------------|
| 1 | Элчин Сайдын 1-р тэрэг, албан ажлын суудлын автомашин /суудлын тоо 5, 2500-4000 cc хөдөлгүүрийн багтаамжтай/ | ш | 2 |
| | Нийт дүн | | 2 |